

ҮНС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 19 -ний өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

2022. 11 сарын 3.

Энэхүү гэрээг Монгол улсын Иргэний хууль бусад хууль тогтоомжийн дагуу нэг талаас “Амгалан дулаан станц” ТӨХК /Цаашид худалдагч гэх/ нөгөө талаас “Монцемент билдинг материалс” ХХК/ Цаашид худалдан авагч гэх/ дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцож байгуулав.

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Монгол улсын “Амгалан дулааны станц” ТӨХК болон “Монцемент билдинг материалс” ХХК нарын хооронд байгуулсан Үнс худалдах, худалдан авах тухай гэрээг хэрэгжүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭ ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 2.1. Талууд энэхүү гэрээний үндэслэл болгосон баримт бичгийн үзэл санааг хэрэгжүүлж олон улсын худалдааны зарчимд нийцсэн, холбогдох хууль тогтоомжийг баримтлан хамтын ажиллагаагаа боловсронгуй болгон харилцан ашигтай ажиллаж, Үнс худалдах, худалдан авах гэрээг хэрэгжүүлнэ.
- 2.2. Энэхүү гэрээг нийлүүлэх үнсний чанар нь стандартын шаардлагыг хангана.
- 2.3. Талууд гэрээгээр тохиролцсон үнэ, хэмжээ, нөхцөлөөр үнс нийлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.4. Худалдагч, худалдан авагчид энэхүү гэрээний дагуу 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 2023 оны 09 сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд өдөрт 30-210 тонн хүртэл үнс нийлүүлнэ. Графикийг хавсралтаар тогтоов.
- 2.5. Талууд гэрээг бүрэн биелүүлсэн нөхцөлд энэхүү гэрээг цаашид үргэлжлүүлэн сунгах, нийлүүлэх үнсний хэмжээг дахин тохиролцож байна.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ

- 3.1. Энэхүү гэрээгээр нийлүүлэгдэх үнсний үнэ 1/нэг/ тонн тутамд НӨАТ тооцсон үнээр 12,500 (Арван хоёр мянга таван зуун) төгрөгөөр тооцоо нийнэ.
- 3.2. Энэхүү үнэнд пүүний бичгийг үндэслэн дараа тооцоот нөхцөлөөр төлөх худалдан авагчийн үнс хүлээн авах талбайд хүргэх төлбөр болон авто зам ашигласны, тээвэр зохион байгуулалт, замын хураамж, шатахууны зардал гэх мэт бусад зардлууд багтсан болно.

ДӨРӨВ. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 4.1. Худалдан авагч нь өөрийн Монцемент үйлдвэрийн пүүгээр үнсийг жинлэн хүлээн авч, үнсний тооцоог сар бүрийн 25-ны өдрүүдэд хүлээж тооцоо нийлж, тооцоо нийлсэн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор Худалдагчийн дансанд шилжүүлнэ.
- 4.2. Энэхүү гэрээний 4.1-д зааснаар төлбөр тооцоог нийлсэн тухайн сар бүр заасан хугацаанд төлөөгүй нөхцөлд нийлүүлэлт зогсоно.
- 4.3. Худалдан авагч тал гэрээгээр авах дараа тооцох нөхцөлөөр төлбөрийг “Амгалан дулааны станц” ХХК-ийн дансанд төлнө. “Амгалан дулааны станц” ХХК-ийн Хаан банкны хүлээн авах дугаар: 5131101050 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.